

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”**

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234733

“ГЭСЭРИЙН ТУУЖ”-ЫН ТУХАЙ

Б.Гонгоржав¹

“Гэсэрийн тууж” буюу дэлгэрэнгүй нэрээр “Арван зүгийн эзэн арван хорын үндсийг таслагч ачит мэргэн Гэсэр хааны тууж оршив” хэмээх зохиол бол манай монголчуудын соёлын өвийн ихээхэн үнэт эрдэнэ мэт зүйл бөгөөд Монголын судар бичгүүдийн дотор товойж үзэгдэх бахдам сайхан дурсгалын хөшөө мэт болой. Товчхон бичиглэлд энэхүү алдарт зохиолын тухай дэлгэрэнгүй шүүмжлэн өгүүлэх бололцоо үгүй хэмээхээс гадна мөхөс хүн түүний гарал үүсэл, хэл найруулгын шинжлэлийн зэрэг нарийн учрыг гүйцэд үл тулгуурлах бөгөөтөл юун аймшиггүй олныг өгүүлэх билээ.

Манай монгол эрдэмтэн мэргэдээс энэхүү Гэсэр богдын туужийг түүхийн ба хэл бичгийн судлалын үүднээс шинжилж байсан удаа хараахан үгүй, харин Гэсэрийн тууж Монголын ард түмний дотор бүтнээр буюу бүлгээр дэлгэрч алдаршсан нь их, судрыг нь шүтээн мэт хүндэтгэж уншдаг, уншихыг олноор сонсдог, дам дам хуулж авдаг, айл саахалтаараа “залж” уншуулдаг, цээж мэддэг хүмүүсээр яриулдаг заншил мэт байсаар ирэв.

Монголчууд энэхүү өвөг эцгээсээ уламжилсаар ирсэн нэртэй зохиолдоо маш энхрий хайртай амуу. Энэхүү зохиолын гарал нь ямар ч байв хэдэн зуун жилийн турш бидний монголчууд нэгэнтээ түүнийг эзэмдэж, уншиж өгүүлэлдэж, барлаж хуулж, үг үсгээр чимж сэтгэлдээ ойр, нүдэндээ дулаан, чихэндээ яруу болгосоор ирсэн болоход мөнөөхөн алдарт “Нууц товчоо”, “Алтан товч” зэргийн амны түүхийн дурсгалт их зохиолуудын нэг адил ямар ч эргэлзээгүй өөрсдийн маань оюун билгийн уран бүтээл юм. Өөрийн маань өмч юм гэж үзнэ.

Төвд, тангад, ойрад ястны зэрэг Ази дахинд мөн байгаа явдал нь “Гэсэрийн тууж”-ыг монголчуудын бүтээл биш хэмээн үзүүлэх баримт биш, харин “Гэсэрийн тууж”-ын төрж гарах цагт Ази дахинаа хүчирхэг бөгөөд улс төр, соёл боловсролын талаар орчин хавийн аймаг, улсуудын дунд нөлөөтэй байсан монголчуудаас бусад улсын иргэн зээлдэн авч өөр өөрийн хэлээр хөрвүүлэн ярьж, өөр өөрийн бичигт буулган бичих зэргээр үг найруулгыг нь хэлбийлгэн засаж Гэсэрийн тухай харилцан ижил бус зохиолуудыг үүсгэсэн байж болно.

“Гэсэрийн тууж”-д гарах зарим баатрууд нь Төвдийн ноёд, хаад буюу зарим учир явдлууд нь Төвд орноо болсон хэмээн өгүүлэгдэх боловч бодвоос Тангадыг

¹ Б.Гонгоржавын бичсэн энэхүү өгүүлэл *Наука - Sinjilekü uqayan* сэтгүүлийн 1944 оны №7 дугаарын 20-23-р талд монгол бичгээр нийтлэгдсэнийг хөрвүүлж тайлбар хийв (Б.Түвшинтөгс).

байлдан эзэлж [байсан ба Тангадын нутаг оронд, жишээ нь Хөхнуурын орчим] нүүдэллэн сууж байсан монголчууд, өөрийн зохиолд төвд хүн, төвд нутгийг хэрэглэсэн нь байж болохгүй зүйл бус буй за. Бас нөгөөтэйгүүр Буддын шашны лам нар бичмэл “Гэсэрийн тууж”-д үе үе гар хуруу оролцож шашны нөлөөтэй болгож, түүний хамт өөрсдийн хэвийн заншлаар уг зохиолын баатруудыг Энэтхэг, Төвдтэй холбож Гэсэрийг бурхны зарлигаар орчлонг ертөнцөд бууж ирсэн хурмаст тэнгрийн хөвүүн болгосон бололтой. Жишээ нь, “Гэсэрийн тууж”-ыг XVIII зууны эхний үед Манжийн Энх-Амгалан хааны зарлигаар Бээжин хотноо модон бараар хэвлэхэд эрдэмтэй лам Жанжаа хутагт уг зохиолыг засамжилсан хэмээнэ. Бас Заяын гэгээн, Өндөр гэгээн зэрэг лам нараас Гэсэрийн туужийг бичүүлж хуулуулж засамжлан чимэг оруулж байсан хэмээнэ. Үүнээс бодвол Гэсэрийн тууж анханд төрийн буюу иргэний чанартай зохиол байсныг лам нар түүнд шашны нөлөөг халдааж үг үсгийг нь удаа дараа засамжилсан бололтой байна. Монголд буддын шашин хэдэн зуун жилээр оршиж байсан болоход түүний нөлөө байх нь арга ч үгүй буй за.

Дорно дахиныг ба тусгайлан Монголыг судлагч Европын эрдэмтэн бол “Гэсэрийн тууж”-ыг монголчуудын утга зохиолын дурсгалт зүйл хэмээн үзэж түүнийг зүйл зүйлээр шинжлэн судлах гэж оролдсоор ирсэн байна. Жишээ нь, 1830 онд эрдэмтэн Я.И.Шмидт “Гэсэрийн тууж”-ыг Бээжин барынхаас герман хэлнээ орчуулж хэвлүүлээд түүнийг судлах талаар ихээхэн ажил хийсэн байна². Я.И.Шмидт “Гэсэрийн тууж”-ыг Монголын баатарчуудын домог хэмээжээ.

Эрдэмтэн Лауфераас Монголын утга зохиолын тухай бичигтээ Гэсэрийн туужийг Монголын бүх утга зохиолын дотор үлэмж сонирхолтой зохиол нь лав мөн бөгөөд түүнд баатарлаг үлгэр, хошигнол, уран шүлэглэл зэрэг холилдон орсон байна хэмээжээ. Лауферийн саналаар “Гэсэрийн тууж” бол Монголын баатарчуудын аман үлгэрийг бичиж бичгийн зохиол болгосон нь болой.

Оросын эрдэмтэн Г.Н.Потанин, А.М.Позднеев нар монгол ойрад нараас Гэсэрийн тухай аман зохиол-үлгэр домгуудыг бичиж олноор цуглуулсан ба тэдгээрийг судалсан байна³. Мөн Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов, С.А.Козин нар “Гэсэрийн тууж”-ыг сонирхож түүнийг утга зохиолын түүх ба хэл дууны талаар шинжлэх ажлыг явуулсан байна⁴. Ялангуяа С.А.Козин бол 7 бүлэгтэй “Гэсэрийн тууж”-ыг орос хэлнээ орчуулж түүнийг шинжилсэн тухай оршил бичиж тайлбарыг хавсарган 1936 онд СССР-ын ШУА-ийн хэвлэлээр нэйтэлсэн байна. Жич, “Гэсэрийн тууж”-ын үгийн санг эрдэмтэн О.М.Ковалевский,

² I.J.Schmidt. *Die Thaten des Vertilgers der zehn Übel in den zehn Gegenden, des verdienstvollen Helden Bogda Gesser Chan: eine mongolische Heldensage: nach einem in Peking gedruckten Exemplare* [Подвиги исполненного заслуг героя Богды Гессер Хана истребителя десяти зол в десяти странах]. St. Petersburg 1836; I.J.Schmidt. *Die Thaten Bogda Gesser Chan's, des Vertilgers der Wurzel der zehn Ubel in den zehn Gegenden: eine ostasiatische Heldensage*. St. Petersburg; Leipzig, 1839.

³ Г.Н.Потанин. *Монгольское сказание о Гэсэр-Хане. По вопросу происхождения русских былин*. Санкт-Петербург. 1890; А.М.Позднеев. *Сказка про сражение Гэсэр-хана с Андалмой*. Калмыцкие сказки-VII. Записки Восточного Отделения Императорского Русского Археологического Общества. Том IX. СПб.: Типография Императорской Академии Наук, 1896.

⁴ Б.Я.Владимирцов. *Монгольская литература*. Литература Востока. Вып. 2. Пб. 1920; С.А.Козин. *Гесериада*. Сказание о милостивом Гесер Мерген-хане, искоренителе десяти зол в десяти странах света. М-Л., 1935.

К.Ф.Голстунский нар өөрийн алдаршсан толь бичгүүддээ өргөн ашигласан байна⁵. Оросын мөн хуучин эрдэмтэн А.А.Бобровников монгол хэлний зүйн дүрмийг зохиохдоо “Гэсэрийн тууж”-ын өгүүлбэрүүдийн найруулгыг барьцаа болгож байсан байна⁶.

Ийнхүү гадаадын эрдэмтдээс манай Монголын “Гэсэрийн тууж”-ыг түүхт том зохиол хэмээн ихэд сонирхон түүнийг олон талаас шинжих ажлыг хийдэг болсон байна. Хэдүй ингэж шинжих ажил хийгдэж буй авч “Гэсэрийн тууж” лугаа холбогдсон бөгөөд шийдвэрлэгдээгүй асуудлууд бас л олон байна. Жишээ нь, Гэсэрийн тууж бол анх ардын аман зохиол байгаад дараа бичгийн зохиол болсон уу, эсвэл уулаас бичгээр зохиогдсон уу? Нэг хүний санаанаас зохиож бичсэн зүйл юм уу, эсвэл үнэн түүхт баримтуудаас сэдэвлэж зохиосон юм уу? Хэрвээ бичгийн зохиол ахул чухам ямар үед хаана хэн гэгч зохиосон бэ? 1717 онд “Гэсэрийн тууж”-ыг Бээжинд барлахдаа чухам ямар эхээс авч барласан бэ? Ямар учраас “Гэсэрийн тууж”-ын хэл нь Өвөр Монголын ордос хавийн аялгуутай вэ? Гэсэр хэмээх нэр хаанаас гарсан бэ? Нангиадын “Гурван улсын түүх” хэмээх зохиолын Гүан жүй хэмээх баатар буюу нангиад нарын шүтээн болгон тахидаг Гэсэр лүгээ холбоо бий эсэх? Төвдийн Лин Гэсэр лүгээ ямар холбоотой вэ гэх зэргийн маш олон асуудалд хариу өгөх явдал шаардагдана.

Гадаадын эрдэмтнүүдээс “Гэсэрийн тууж”-ыг сонирхож судалж байхад манай Монголын түүх судрыг шинжлэх оюутан өөрийн эцэг өвгөөс уламжлан ирсэн өв хөрөнгө болох алдарт зохиол юугаа шинжлэх ухааны үүднээс нарийн судалж, түүний түүх гарал зэргийг тодотгох явдал нэн чухал болохыг заан өгүүлэх, ийнхүү “Гэсэрийн тууж”-ыг шинжих явдлыг дөхөм болгохын тулд Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Хэл бичгийн тасгаас 19 бүлэгтэй “Гэсэрийн тууж”-ыг нийтлэхээр боловсруулан бэлтгэж буй. Энэ нийтлэгдэх “Гэсэрийн тууж”-ыг Улсын номын сангийн Азийн ангид буй “Заяын хүрээнээс олдсон Гэсэр” хэмээн бүртгэгдсэн 18 бүлэг бичмэл Гэсэр, мөнхүү номын санд буй хаанаас ирсэн нь үл мэдэгдэх 3-аас 8-ыг дуустал бүлэг бичмэл Гэсэрийг хооронд нь нийлүүлэн энэхүү урьд нийтлэгдэж байгаагүй бүрэн дүүрэн бүлэгтэй болгов. Энэхүү бидний нийтлэхээр бэлдэн буй “Гэсэрийн тууж”-д мөнөөхөн Бээжингийн модон барын 7 бүлэг Гэсэр цөм багтаж оролцсон дээр нэр дурдсан бичмэл Гэсэрүүдэд байгаа илүү бүлгүүдийг [жишээ нь, Нандуламын тухай, чөтгөрийн Номбо хааны тухай гэх зэрэг бүгд 12 шинэ бүлэг нэмж нийт 19 бүлэг, эдгээр шинэ нэмэгдсэн 12 бүлгийн дотроос 8, 9, 10, 12, 13, 15-р бүлгүүдийн эх бичиг нь үүний урьд СССР-ын ШУА-ийн Азийн музейд байсан боловч эдүгээ хүртэл шинжлэгдэн хэвлэгдээгүй байна. Саяхи Азийн музейд 11 ба 14-р бүлгүүдийн бичмэл байхгүй аж. Бас нас барсан академич Б.Я.Владимирцовт 8 ба 9-р бүлгүүдийг багтаасан Гэсэрийн тууж ойрад хэл дээр байсан хэмээх боловч мөн л хэвлэгдээгүй байна. Н.Н.Поппегийн бичсэн нь⁷: “Эдгээрийн дотроос [Азийн музейд буй бөгөөд хэвлэгдээгүй бүлгүүдийн дотроос Г.] 11

⁵ О.М.Ковалевский. *Монгольско-русско-французский словарь*. Том. 1-3, Казань 1844, 1846, 1849; К.Ф.Голстунский. *Монгольско-русский словарь в трех томах с добавлениями и посмертными дополнениями, составленными Рудневым*. СПб., 1895-1901.

⁶ А.А.Бобровников. *Грамматика монгольско-калмыцкого языка*. Казань. 1849.

⁷ Poppe N.N. *Geserica. Untersuchungen der sprachlichen Eigentümlichkeiten der mongolischen Version des Geser-khan*. Asia Major-3, 1926.

ба 14-р бүлгүүд нь дутуу боловч энэ хоёр бүлгийн лав буй болох нь хойших бүлгүүдээс илт буй” хэмээснээс гадна “сүүлчийн [шавхарсан Г.] 4 бүлэг буюу 10, 12, 13, 15-р бүлгүүд нь Азийн музейд хэмээн бүртгэгдсэн байна” хэмээжээ. Үүнээс үзвэл Н.Поппе “Гэсэрийн тууж”-ыг 15 бүлгээр шавхрах мэт бодсон ба 11, 14-р бүлгүүдийн бичмэл олдоогүй хэмээсэн байна. Бид тэрхүү дутуу 11 ба 14-р бүлгүүдийн эх бичмэлийг олдсон гэж санах ба тэр нь эдүгээ Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс хэвлүүлэхээр бэлдэн буй “Гэсэрийн тууж”-д орно. Жич, Европын эрдэмтнээс буй хэмээн урьд дурсаж байгаагүй 16, 17, 18, 19-р бүлгүүд шинээр олдож түүхэнд анх удаа хэвлэлд нийтлэгдэхээр буй бүлгүүдийн агуулгыг энэхүү товч бичмэлд бичихийг хэмнэж зөвхөн цухас тэмдэглэх нь, ийнхүү “Гэсэрийн тууж”-ын дутуу байсан бүлгүүд шинээр олдож хэвлэгдэхээр буй нь манай монголчуудын алдарт сайхан утга зохиолын дурсгал болсон зохиолыг бүрэн төгс болгохын зүгт ихээхэн ахиулсан ба Монголын хуучин утга зохиолыг шинжлэгч нараас түүнийг судлан шинжлэхэд амар дөхөм бөгөөд сонирхол үлэмжтэй болгосон явдал болно.

Алдарт “Гэсэрийн тууж”-ыг урьд хожид хэвлэлд нийтлэгдээгүй том хэмжээгээр анх удаа боловсон хэвлэлээр дармаллан гаргах явдлыг манай Монголын ба гадаадын сэхээтэн сайшаан хүлээж авах буй за.

Жич, Нандуламын бүлэг нь мөнөөхөн А.М.Позднеевээс Халимаг нутгаас ойрад хэл дээр олсон Нандулам лугаа утга адил боловч түүний орчуулга бус уулаас монгол хэл дээр байсан бүлэг амуй. Иймд А.М.Позднеевийн олсон ойрад Нандуламын бүлэг нь дан гагц ойрадын юм бус харин угийн монгол Гэсэрийн нэг бүлэг нь болох үүнээс илт буй за.

Жич, Шинжлэх Ухааны Хүрээлэнд “Гэсэрийн тууж”-ын тухай бас бус мэдээ баримт буй бөгөөд тэр нь тодорхой шинжлэлийн бичигт дараа нийтлэгдэх болно.

Манай бүрэн “Гэсэрийн тууж” бол үнэхээр мөнөөхөн Эртний Герегийн Илиада, Одиссей хэмээх мөхөшгүй зохиолтой зэрэгцэх ажгуу.

Гэсэрийн туужийн олон янзын бичмэлүүдийг эрж олох ба цээжээр мэдэгчдээс бичиж авах ажил үүгээр хязгаарлагдах бус цаашид явуулагддаас зохих зүйлийн нэг мөн. Цээжээр мэддэг настай хүмүүсийн амьд байгаа дээр нь хэлүүлж бичиж авах явдал маш чухал бөгөөд үүнийг эс анхаарваас хойд үед мартагдаж балрахад мөн болохоос гадна юмны учрыг мөчид мэдэх зарим этгээдүүд хуучны үнэтэй түүх судрыг дайсагнан үзэх, шатаах, устгах, уншигчдыг айлган сүрдүүлэх зэргийн балмад явдал гаргадаг нь туйлын жигшүүртэй амуй.